



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 5/19.

Дуурлиг

┌ Арга зүйч С.Оюунтуяад ажил хавсран ┐
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар хуулийн 33.3.1, 33.3.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх заалт, Монгол улсын Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 тоот тушаалын заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Арга зүйч С.Оюунтуяад 2024 оны 9 дүгээр сарын 1 ний өдрөөс эхлэн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцах ажлыг хавсран гүйцэтгүүлсүгэй.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийж ажлыг сайжруулан үр дүнтэй, хариуцлагатай ажиллахыг арга зүйч С.Оюунтуяад үүрэг болгосугай.

3. Арга зүйч С.Оюунтуяад ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг 2024 оны 09 дүгээр сарын 01 нээс эхлэн үндсэн цалингийн 40% иар тооцон сар бүр олгохыг нягтлан бодогч /Н.Цолмонбаярт/ зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ

Г.АЗЖАРГАЛ

